



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 24 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 24 дүгээр хуралдаан 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр болов.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 24 дүгээр хуралдаанаар /2025-11-28/ “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын үнэлгээний ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийн тухай (Хорооны 2025 оны 216 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Ийзи гөү рөүд ХХК-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай ажлын хэсгийн санал, дүгнэлтийн тухай) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 5 (Тогтоол №244-248, 2025-11-28) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 21 дүгээр хуралдаанаар /2025-10-10/ Хорооны 2025 оны 216 тоот “Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай” (Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт) тогтоолыг баталж, энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ХХЗХ-2025 /УБДД-СШ-01/ тоот “Улаанбаатар хотод Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай зарласан болно. Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 24 дүгээр хуралдаанаар дээрх сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан Үнэлгээний ажлын хэсгийн зохион байгуулсан ХХЗХ-2025 /УБДД-СШ-01/ тоот сонгон шалгаруулалт”-ын үйл ажиллагаа, үнэлгээ гүйцэтгэсэн тайлан тэмдэглэл, холбогдох танилцуулга, үнэлгээний ажлын хэсгийн санал дүгнэлт болон “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолын төслийг тус тус авч хэлэлцүүлэв. Тус хуралдаанаар 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 245 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлан шийдвэрлэв. Үүнд: Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Зохицуулах хорооны даргын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/254 дугаар тушаалаар байгуулагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай” сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 245 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Тус хорооноос зарласан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай

зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-д Монголиан мюзик медиа ХХК 94.86 оноогоор нэгдүгээрт, Хэмнэлт долгион медиа групп ХХК 80.86 оноогоор хоёрдугаарт, Шүхэр НҮТББ 80.57 оноогоор гуравдугаарт, Монгол комикс ХХК 75.43 оноогоор дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж, шалгарсанд тооцсугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд 14 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 24 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Ийзи гөү рөүд ХХК-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай ажлын хэсгийн санал, дүгнэлт болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 3 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 3 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 246 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Жаргалант эвсэг оптик ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 247 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Юнител ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” /1616 МГц – 1626.5 МГц/ 22300005 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 248 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Ийзи гөү рөүд ХХК: “Харилцаа холбооны сүлжээ байгуулах түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх” 17000006 тоот тусгай зөвшөөрлийг) 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлж тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-12-08